

Ардын дууны судлалд
профессор Эрдэнэбилигийн оруулсан хувь нэмэр

Дашзэвэгийн ӨРНӨХДЭЛГЭР*

Монгол Улс, Ховд хот, Монгол Улсын Их Сургууль, Баруун бүсийн сургууль

Намжилын БАЯРСАЙХАН

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Их Сургууль,
Мэдээллийн технологи, Электроникийн сургууль

Батсуурийн СУВДАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улсын Их Сургууль,
Мэдээллийн технологи, электроникийн сургууль, Мэдээлэл, компьютерын ухааны тэнхим

Received: 31 May 2025 / **Accepted:** 15 October 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Бид энэ өгүүлэлдээ профессор Эрдэнэбилигийн ойрад ардын дууны судалгааг онцлон авч үзсэн болно. Ойрад ардын дууны судалгааны тоймыг Монгол улс төдийгүй Шинжаан, Хөхнуур, Гансү, Алишаа, Эзнээ болон бусад улс орны хүрээнд гаргаж, ардын дууны үүслийг эртний түүхэн сурвалж, домгоос эрж хайсан байна. Ойрад ардын дууны нэрийн онцлог хийгээд дуулах ур мэргэжил, ёс заншлыг нарийвчлан авч үзсэн төдийгүй ойрадын олон угсаатан тус бүрийн ардын дууны онцлогийг тодорхой гаргажээ. Түүнчлэн ойрад ардын дууг сэдэв агуулгын хүрээнд хөдөлмөрийн дуу, түүхт дуу, найр хуримын дуу, аж байдлын дуу, бүүвэйн дуу, хохир дуу гэж хуваан судалжээ. Мөн ойрад ардын дууны үндэстний шинж, хөг ая хийгээд сэтгэлгээний онцлог, ойрад ардын дууны илтгэх арга хийгээд ардын дууны бүтэц, савардан дуу бүжиг, ойрад ардын дуун дахь морины зүсэм, өгүүлэмж ойрад ардын дуу хийгээд тэмээн соёл гэсэн өргөн хүрээнд судалгаа хийсэн байна.

Түлхүүр үгс: Ардын дуу, ойрад дуу, Эрдэнэбилиг, машин тооцоолол

Professor Erdenebilig's Role of Research for Folk Songs

URNUKHDELGER Dashzeveg

Western Regional School, National University of Mongolia, Khovd, Mongolia

BAYARSAIKHAN Namjil

School of Information Technology and Electronics,
National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

SUVDAА Batsuuri

Department of Information and Computer sciences, School of Information Technology and Electronics,
National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

* © Author(s) 2025, Email: urnukhdelger@num.edu.mn <https://orcid.org/0000-0002-3099-5710>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Abstract: *Erdenebilig, a professor at Northwest University of the People's Republic of China, a researcher of oral literature and etiquette, is a tireless worker and eternal seeker who has dedicated his entire life to academic research, absorbing various knowledge and experiences and guiding dozens of scholars along the way. He is a reliable pillar of Mongol studies. Scholar Erdenebilig's research in the field of oral literature, etiquette and education is in the focus of Mongolian scholars around the world, and his scientific works and articles on this topic are widely cited and already well known in academic and cultural circles. In this paper, we will focus on Professor Erdenebilig's research on Oirat folk songs. He conducted research on Oirat folk songs not only in Mongolia but also in Xinjiang, Hokhnuur, Gansu, Alshaa, Ezne and other countries, and explored the origins of folk songs in ancient historical sources and legends. He not only examined in detail the features of Oirat folk song titles, singing skills and customs, but also carefully described the features of folk songs of each of the many Oirat ethnic groups: in addition, he divided Oirat folk songs into songs on work or labor, historical songs, songs, for weddings and festival, everyday or lifestyle songs, lullabies and songs of suffering. He also conducted extensive research on the ethnic features of Oirat folk songs, the features of their melody and mentality, the expressive means of Oirat folk songs and the structure of folk songs, Savardan songs and dances, horse color and legends in Oirat folk songs, Oirat folk songs and camel culture. As an ancient Indian legend says "When a beauty steps on a dry tree, flowers and fruits grow on its branches", anyone who follows the path, teachings and instructions of Professor Erdenebilig, who enlightens people, will be honored as a person blessed with the fruits of wisdom, as if he received the gift of eternal youth. Thanks to his extraordinary mind, he was honored as a deeply specialized scholar of the Oirat's folk song study.*

Key words: Folk Song, Oirat Song, Erdenebilig, Mashine Learning

1. Удиртгал

Монгол соёл, монгол зан заншил, эрт эдүгээгийн уламжлалд элэг зүрхнээсээ үнэнч, БНХАУ-ын Баруун хойдын үндэстний их сургуулийн профессор, аман зохиол, зан үйл судлаач Эрдэнэбилиг нэг насны ухамсарт амьдралаа эрдэм судлалын ажилд зориулж яваа цуцашгүй хөдөлмөрч, мөнхийн эрэлчин, тал бүрийн мэдлэг туршлагыг өөрийн ухаан бодолдоо цогцлоосон, түүнийхээ зам мөрөөр олон арван эрдэмтэн судлаачдыг дагуулан сургасан Монгол судлалын бат суурьтай нэгэн тулгуур багана юм. Эрдэмтэн Эрдэнэбилигийн аман зохиол, зан үйл, сурган хүмүүжлийн талаар хийсэн судалгаа шинжилгээний ажил нь дэлхийн монгол судлаачдын анхаарлын төвд байж, эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл, өгүүллүүд нь олонтоо эшлэгдэж эрдэм соёлын хүрээнд нэгэнт танигдсан байна. Профессор Эрдэнэбилиг нь 1958 оны 12 сарын 15-ны өдөр Өвөр монголын өөртөө засах орны Алшаа аймгийн Баруун хошуунд төрсөн. 1983 оны 7 сард Баруун хойдын үндэстний их сургуулийн Цөөн тоот үндэстний хэл утга зохиолын салбарыг төгсөөд тус сургуульдаа үлдэж багшилжээ. 1985-1986 онд Өвөр монголын багшийн их сургуулийн туслах багшийн ангид утга зохиолын чиглэлээр аспирантаар сурч, 1998-2001 онд Төвийн үндэстний их сургуулийн Монгол хэл, утга зохиолын салбарт аман зохиолын аспирантаар суралцаж, хэл бичгийн ухааны дэд эрдэмтний цол хамгаалж, 2001-2002 онд Улсын сурган хүмүүжлийн яамны томилолтоор МУИС-д уран зохиол судлал, аман зохиол, зан үйлийн ухааны чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн юм.

1990-1993 онд Цөөн тоот үндэстний хэл утга зохиолын салбарын албан гэрийн эрхлэгч, 1993-2000 онд Монгол хэл зохиолын салбарт хичээл хүмүүжлийн ажлыг хийхийн хамт салбарын албан гэрийн эрхлэгч, 1997-2004 онд монгол хэл зохиолын зохиолын салбарын дэд захирлын тушаалыг хариуцсан байна. 2004 оноос 2017 онд Монгол хэл соёлын дээд сургуулийн захирал, Баруун монголын соёл судлах газрын даргаар ажиллажээ. Эдүгээ Баруун хойдын үндэстний их сургуулийн Дундад улсын хэл зохиолын хэлтсийн хоёрдугаар дэсийн профессор, докторантын удирдагч багш, улсын заан сургах бүлгэмийн дагуулагч, улсын онцлогт мэргэжлийн дагуулагч, мужийн голлох шинжилгээний салбарын дагуулагч, сургуулийн “Арван шилдэг багш”, сургуулийн дэсийн нэрт багш зэрэгтэйгээр ажиллаж байна.

Тэр бээр Сурган хүмүүжлийн яамны эрдэм шинжилгээний томоохон төслүүдийг гүйцэтгэж байна. Улсын хэвлэлийн суурь мөнгөний шинжилгээний салааны хянан тогтоох эрдэмтэн, Улсын нийгмийн шинжлэх ухааны эрдэм шинжилгээний төслийг хянан тогтоох эрдэмтэн, Дундад улсын монгол утга зохиолын нийгэмлэгийн хэрэг эрхлэх газрын дэд дарга, Монгол улсын Улаанбаатарын их сургуулийн зочин профессор, Бүх улсын дээд сургуулийн монгол заах бичиг хянан тогтоох комиссын гишүүн, Өвөр монголын зан үйлийн шинжилгээний нийгэмлэгийн гишүүн, Өвөр монголын үндэстний их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, Дундад улсын Монгол судлал сэтгүүлийн онц урьсан найруулах комиссын гишүүн, Өвөр монголын ардын аман зохиол урлаг шинжлэлийн судлах хурлын онц урьсан эрдэмтэн зэрэг нийгмийн үүрэг тушаалыг хариуцаж байна.

“Монгол уран зохиолын хөгжлийн товчоо” (хамтын) бүтээл нь 1996 онд ӨМӨЗО-ы тавдугаар удаагийн нийгмийн шинжлэх ухааны шилдэг бүтээлээр шалгарч, “Монгол ардын аман зохиолын удиртгал” (Бүх улсын дээд сургуулийн заах бичиг) 2002 онд Өвөр монголын өөртөө засах орны их дээд сургуулийн шилдэг сурах бичгээр шалгарч, 2008 онд тус ном ӨМӨЗО-ы хоёрдугаар хугацааны гүн ухаан нийгмийн шинжлэх ухааны шилдэг бүтээлийн засгийн ордны хоёрдугаар дэсийн шагналаар шалгарч, 2009 онд Алшаад болсон бүх улсын анхдугаар удаагийн ойрад монгол ардын дууны эрдэм шинжилгээний хуралд “Ойрад монгол ардын дууны цуглуулга судлалын тойм” хэмээх өгүүлэл нь нэгдүгээр дэсийн шагналыг хүртэж “Дээд монголын ардын аман зохиолын судлал” ном нь 2012 онд Хөхнуур мужийн ардын утга урлагийн гуравдугаар дэсийн шагналыг хүртсэн байна. Тэр бээр Ганьсу мужийн “Турамсан хүмүүжлийн шилдэг хувь хүн”, “Ганьсу мужийн сурган хүмүүжлийн тэнхимийн дээд сургуулийн хичээл хүмүүжлийн чанар чансааг шалган хянах ажлын жишээч”, “Ганьсу мужийн дээд сургуулийн оюутнуудын нийгмийн үйлчилгээний багийн шилдэг жолоодогч багш”, “Судлан сурагчийн эрдмийн зэрэг хамгаалсан өгүүллийн шилдэг удирдагч багш” зэрэг шагналыг хүртсэн байна.

2. Ардын дууны судлалд оруулсан хувь нэмэр

Монголчууд биднийг дэлхий дахинд ондоошуулж байдаг бахархалт өв, соёлын маань нэг бол яах аргагүй ардын урлаг тэр дундаа уртын дуу билээ. Нэгэн цагт дэлхийн дайдыг хэмжиж явсан баатарлаг дээдсийн минь үеэс үед өвлүүлж үлдээсэн энэхүү гайхамшигт өв, соёлоо бид түүх угсаатан, соёл урлаг, утга зохиол, хэл шинжлэл зэрэг бүхий л талаас судлан сурвалжилж, өвлөн дэлгэрүүлэх үүргийг хүлээх нь дамжиггүй. Иймдээ ч монгол угсаатан амьдран буй аль ч газар оронд нутаг нутгийн онцлог, үүх түүх, соёл уламжлалаа тээн үлдсэн ардын дуу, уртын дуугаа судлан өргөжүүлсээр байна. Тэдний нэг бол Өвөр монголын Баруун хойдын үндэстний их сургуулийн профессор, аман зохиол судлаач, доктор Эрдэнэбилиг юм.

Ардын дуу, уртын дууны судалгаа Монгол улс, ОХУ, БНХАУ-аас гадна монгол судлал өргөжин хөгжиж буй дэлхийн олон оронд хийгдсээр байна. Харин энэхүү бүтээл шиг өргөн агуулга, сэдвийн хүрээнд судлан нэгэн дэвтэрт буулгасан нь ховор. Үүгээрээ энэхүү судалгааны бүтээл аль ч үеийн судлаачдын хувьд үнэ цэнтэй судалгааны эх хэрэглэгдэхүүн болж байна. Энэ их мэдээллийг эмхлэн цуглуулж эрхлэн хэвлүүлнэ гэдэг маш их цаг зав, эрдэм мэдлэг шаардсан ажил учраас профессор Эрдэнэбилиг Ойрад ардын дуу судлалд үнэлж баршгүй гавьяа байгуулсан эрхэм юм.

Уг бүтээлийн үнэ цэнийг урлаг судлалын ухааны доктор, профессор Ж.Энэбиш “Эрдэмтэн Эрдэнэбилиг дуу судалж, дуугаар хөшөө босгожээ. Энэ ажил амар хялбар бүтээгүй нь мэдээж. Ази европ тивд тархан, хэдэн мянган жилээр амьдарч байгаа монголчуудынхаа өв соёлыг тээгч олон зуун авьяастантай уулзаж, эрдэнийн эрэл хийжээ. Эрдэнийн эрлийн эцэст олсноо нэгтгэсэн нь таны өмнөх энэ бүтээл болой. Энэ бүтээлийг хэн нэгэн хүн гүйцэтгэж болох байсан хэдий ч, гагцхүү Эрдэнэбилиг профессор хийж чаджээ. Энэ бүтээлийн агуулга гүн, ач холбогдол арвин юм. Нүүдлийн соёл иргэвшил, суурин соёл иргэвшил зэрэгцэн оришиж, дэлхий даяаршин, хүн төрөлхтөн соёлоор харилцан нэгдэж, өв соёлыг эрхэмлэн дээдэлж байгаа эрин үед энэ бүтээл өргөн олон түмэн, эрдэм судлагчдын өмнө сүндэрлэн босож байгаа нь бүр ч чухал ач холбогдолтой” (Эрдэнэбилиг, 2024:3) хэмээн

үнэлжээ. Эрдэмтэн хүнд хамтран зүтгэгч эрдэмтнээс нь түүний ололт амжилтыг хүлээн зөвшөөрөхөөс илүү дээд шан үгүй бөгөөд энэ нь эд материалтай зүйрлэшгүй илүү үнэ цэнтэй байдаг.

Нийт 14 бүлэг (өгүүлэмж) энэхүү бүтээлд Ойрад ардын дууны цуглуулга, судлагдсан байдал, дууны үүсэл, хөгжил, дууны нэр, дуулах арга ухаан, ёс заншлын талаас маш дэлгэрэнгүй судлан оруулснаас гадна Ойрадын угсаатан ястан бүрийн дууны уламжлал, онцлог, хөдөлмөрийн хийгээд зан үйлийн дуу, түүхэн хийгээд аж байдлын дуу мөн түүнчлэн дуутай бүжгийн уламжлал, Ойрад дууны аялгуу болон шүлгийн онцлог, Ойрад ардын дуунд тусгалаа олсон малын зүс, мал аж ахуйн соёлын онцлогийг маш дэлгэрэнгүй судлан оруулжээ.

Нэгд: Ардын дууг анх хэн нэг ямар нэгэн зүйлд зориулан зохиож улмаар амнаас ам, нутгаас нутаг дамжин өвлөгдөж нутгийн ардын дууны шинж, намба төрхөө олдог нь жам юм. Яг ийм л жамаар Ойрад ардын дуу өнөө бидний үед уламжлагдан ирсэн. Уртын дууг өнөө цагийн хөгжмийн тэмдэглэл болох нотоор зохиох боломжгүй байдаг талаар хуучны уртын дуучид төдийгүй өнөө цагийн хөгжмийн зохиолчид ч цохон хэлсэн нь бий¹. Ийн зохиогдсон дуу нь шүлгийн задгай хэмнэлээр, аялгууны чөлөөт зохиомжоор бүтсэн байдаг. Профессор Эрдэнэбилиг ч тус бүтээлдээ энэ талаар өгүүлсэн байна. Тэрээр *“Эрт үеийн ардын дуучдыг чөлөөт дуучин буюу задгай дуучин гэж хэлж болно. Учир нь тэд дууны ноот (эгшиглээс)-ыг мэдэхгүй, түүнийг тэмдэглэх арга барил, жам ёсыг ч мэдэхгүй, тэд өөрийн дур сэтгэлээрээ эрх чөлөөтэй дуулж сэтгэл санаагаа илтгэж байдаг. Нэмж хэлэхэд, нүүдэлчин ардын бүхий л соёл нь задгай соёл, эрх чөлөөтэй, нээлттэй соёл болно. Энэ нь уртын дууны хөг аялгуутай нь нягт харьцаа холбоотой юм”* (Эрдэнэбилиг, 2024:84) гэжээ. Харин аялгууны хувьд халх уртын дууг айзам, суман, бэсрэг хэмээн хэмжээний хувьд ангилан айзам уртын дууг төрт ёсны хүндэтгэлт үйл явдалдаа зориулан дуулдаг бол суман дууг хаана ч, хэн ч, хэзээ ч дуулж болдгоороо онцлогтой, харин бэсрэг уртын дуу бол голдуу захин сургасан утга агуулгатай байдаг учраас найр жаргаах зэрэг зан үйлд дуулдаг. Төв халхын айзам уртын дуу давхар шуранхай, уран нугалаа ихтэй уртын дууны хамгийн том хэмжээний бүтээл бол суман болон бэсрэг дуу нь үүнээс хэмжээ царааны хувьд арай бага байдаг. Харин Ойрад угсаатны дууны хувьд Үзэмчин ардын дуу дунд хэсгийн хоолойн нугалааг илүү хэрэглэж байхад, Алшаа ардын цайруулга шургуулга зэрэг хоолойн ая нугалааг илүү хэрэглэж, Хорчин ардын дууны олонх нь хий, эрүү нугалаагаар голлосон дуулалттай байж, Ордос ардын дууны хөг ая огцом мөртөө түрлэгээр голлуулсан хийн нугалаат дуулалт голлож, Хөлөнбуйрын ардын дуу тагнайн нугалаагаар голлож дуулдгаараа тус тусын нутаг орны онцлогоо илрүүлж чадсан байдаг талаар Эрдэнэбилэг профессор тодорхойлжээ. Эндээс харахад Ойрад ардын дуу нь төв халхын суман болон бэсрэг уртын дууны хэмжээнд дуулагдан уламжлагдсан байна.

Хоёрт: Монгол уртын дууны шүлэг анх аялгуундаа зохирон шууд зохиогддог байсан учраас шүлгийн нэр гэхээсээ илүү эхний мөрийн эхний үгсээр дуугаа нэрлэдэг байсан уламжлал Ойрад нутагт мөн энэ л хэвээр уламжлагджээ. Монгол ардын дууны бичмэл дэвтрүүдээс үзэхэд зөвхөн уртын дууг эмхэтгэн бичиж байсан нь илэрхий. Ингэхдээ шүлэглэсэн маягаар бус харин үргэлжилсэн үгийн хэлбэрээр бичих боловч олонх дууны нэр гарчгийг тусгай заан бичдэггүй тул эхний мөрийн үг буюу утга санаагаар чухам ямар дуу болохыг оноон нэрлэдэг. Ерөөс Монголчууд нүүдэлчин ахуйн онцлогоосоо шалтгаалж түүх, шастираа ном сударт хадгалахаасаа илүүтэй цээжнээс цээжинд дамжуулан өвлүүлж ирсэн эртний уламжлалтай ард түмэн. Энэ уламжлалын дагуу ардын дууны шүлгүүд амнаас ам дамжин өвлөгдөж, ихэнх дууны шүлэг анх зохиосон эзэн нь тодорхойгүй болсон байдаг. Академич Ц.Дамдинсүрэн: *“Монголд урьд цагт тусгайлан зохиосон шүлэг бараг байгаагүй. Одоо л уншигчдад зориулсан, тусгайлан бичсэн шүлгүүд бичигдэж байна”* гэжээ. Уртын дууны шүлэг ч энэ зарчмаар уламжлагдан ирсэн. Эртний уламжлалтай уртын дуу (Айзам голдуу)-ны

¹ Монгол Улсын Гавьяат жүжигчин, Төв халхын алдарт уртын дуучин Чойжилын Намжил энэ тухай өгүүлсэн байдаг. Тэрээр өөрийн багш Алдарт гавьяат дуучин, XX зууны манлай эрэгтэй уртын дуучин Жигзавын Дорждагваас сурсан дуулах арга ухаан, унаган авьяас, нутаг усаа санасан сэтгэлийн гүнээс ундарсан аялгуугаар таван уртын дуу зохиосон юм. Мөн хөдөлмөрийн баатар, төрийн хошой шагналт, урлаг судлалын ухааны доктор, профессор, хөгжмийн зохиолч Н.Жанцанноров уртын дууг нотоор зохиох боломжгүй талаар өгүүлсэн нь бий.

шүлгүүдээс энэ байдал тодорхой харагдана. Монгол ардын дууны үг, аялгуу хоёр нь маш нарийн шүтэлцээтэй бөгөөд ялангуяа уртын дуу нь ямагт сонгодог бичгийн хэлний найруулгатай буюу эрдэмтэн Б.Я.Владимирцовын нэрлэснээр “ном, бичгийн хэлний үгсээр” зохиогдсон байдаг. Сонгодог найруулга нь хүндэтгэлийн утга илэрхийлж байдаг (Дулам, 2007: 65-66). Айзам хэмжээний уртын дууны шүлэг ихэвчлэн задгай шүлгийн ёсыг баримталдаг, уянгын яруу найргийн хэлбэрээр уламжлагдаж ирсэн байдаг бол суман болон бэсрэг уртын дууны шүлэг голдуу чанарын шүлгийн өргөлтөт болон үе өргөлтөт зүйлээр бичигдсэн байдаг. Энэ байдлыг Ойрад уртын дууны шүлэг болон Эрдэнэбилиг профессорын энэхүү судалгаанаас тодорхой харж болохоор байна.

Гуравт: Шинжлэх ухааны хэл найруулга эгэл энгүүн, эх сурвалжийг тухай бүрд нь хадаж өгсөн, арга зүйн хувьд **ерөнхийгөөс тусгай** руу чиглэсэн аястай байна. Тиймээс ч, “Ардын дуунд үндэстэн ястны гүн зузаан хайр сэтгэл, хэв заншил, аж амьдрал, хүсэл эрмэлзэл бүрэн тусгалаа олж, үг аяар дамжуулан амьдрал ахуй, түүх соёл, зан үйлийг уламжлан дэлгэрүүлж, ард түмэнд цаг алдалгүй сануулан сургаж, сэрэмжлүүлэн хэлж өгдөг аман ухуулга, нүүдэлчдийн “аман сонин”-ы үүргийг гүйцэтгэж байдаг тул цаг үе ба нийгмийн амьдралын нэвтэрхий толь болж чаджээ” (Эрдэнэбилиг, 2024: 14) хэмээн дүгнэсэн байна. Өөр нэг шинжлэх ухааны өнцөг нь **шалтгаан – үрийн** холбоог нарийн гаргаж уялдуулсан шинжлэх ухаанч бүтээл болжээ. Эх байвал эцэг байж, эцгээ магтсан, эцгийн ач гавьяаг дурсан санагалзсан дуу ойрад түмний дунд цөөн бус байдгийг нэгэн адил дурдах ёстойг онцгойлон тэмдэглэжээ.

Түүнчлэн **эсрэг – тэсрэгийн** нэгдлийг уялдуулж зүйл тухай бүрд гаргалга хийсэн нь сонирхолтой бөгөөд энэ нь өрнө дахины томьёоллоор бол Францын алдарт бүтэц зүйн онолч Клод Леви-Строссын “хосмолжин эсрэгцэл”-ийн (opposition binaire) онол билээ. Монголчууд сав шим ертөнц, эд өлгийн зүйлийг ямагт арга билгийн хосмолжин барилдлагаар харж сэтгэдэг уламжлалтай байжээ. Нэр томьёоны хувьд өнөөгийн “арга билиг” гэдэг нь бурхны шашин гүн ухааны “Тав-Шэйрав” (thads-shes-rab) гэдгийн монгол орчуулга мөн бөгөөд монголчууд өөрсдөө энэхүү ойлголтыг “тэнгэр-газар”, “эр-эм”, “наран-саран”, “суб-зали”, “хар-цагаан” гэхчлэн янз бүрээр нэрлэж ирсэн бөгөөд тоог гэхэд эр тоо, эм тоо, өнгийг гэхэд эцэг өнгө, эх өнгө, сайн муу үйлийг хар цагаан чулуугаар төлөөлүүлэн тэмдэглэдэг байжээ. “Суб-зали” (sub-jalin) гэдэг нь ус, гал хоёроор хүний суу ухаан, арга чадлыг бэлгэдэн төлөөлүүлсэн чухамдаа арга билиг гэсэн үг болно. Иймээс зохиогчид монгол ардын дууг “*«цулгай» буюу «богино»-оос мултарч, «дэлгэрэнгүй» буюу «урт» зүг хөгжин баяжиж ирсэн түүхтэй*” (Эрдэнэбилиг, 2024: 74) гэж үзсэний дээр монголчуудын хүсэл бодлын гоо сайхны нэг бол найрт гурван дуутай, наадамд гурван даваатай байхыг хүсдэг бол, эцэг эх бологсод үр хүүхэдтэй байхыг хүсэж, эх бологсод үр хүүхдээ бүүвэйн дуугаар сурган хүмүүжүүлж, ухаан санааг нь тэлж хүн болгон хүмүүжүүлж ирсэн түүхтэйг онцлон дурдсан байна.

Ард түмэн өөрийн нүдээрээ үзэж чихээрээ сонссон бодит хэрэг явдлыг сонгон авч уран сэтгэмжээр баяжуулан тухайн нийгмийн байдлыг зураглан тусгасан олон сайхан ардын дууг зохион бүтээсэн байдаг онцлогийг судлан бичихдээ **бодит- хийсвэрийг** хослуулсан онцлог эл бүтээлд нэвт шингэжээ. Үүнийг илтгэх жишээ нь, “*Монгол ардын түүхт дуунд угсаа ястны ашиг тусын төлөө эрэлхэг баатарлагаар тэмцсэн гарамгай хүмүүсийн үйлс гавьяа, түүхэн үйл явдлын ул мөрийг нэлээд оновчтойгоор тусгаснаар барахгүй, тухайн үеийн түмэн олны бодол сэтгэл, хүсэл эрмэлзэл бүхнийг “Халзан шарга”, “Халиун морь”, “Цоохор морь”, “Саарал морь” гэх зүсмийн морьдоор дамжуулан илтгэж, “Дөнөн шарга”, “Хар дэлтэй”, “Хөх дэлт” гэх мэт үгийг хэрэглэж хүч чадлын бэлгэдэл буюу Чингис хааны “Найман морьд”-ын зүсмээр хүндэтгэл бэлгэдлийн санаагаа нэн амьдлаг сайхан илэрхийлсэн байна*” (Эрдэнэбилиг, 2024: 192) гэсэн энэ хэсэг юм.

Ардын дууны нэгэн онцлог нь **орон нутгийн шинжээс- үндэстний сэтгэлгээний** илэрхийлэл болж тэлдэг гэдгийг эл бүтээл баталсан байдаг. Тухайлбал, Дөрвөн зүгээр бадаг эхлүүлж дуулдаг. Монголчууд дөрвөн зүг, дөрвөн улирлаар байр бэлчээр, гэр орноо болгож ирсэн тул олон чигт амьдрал бол тэдний амьдралын гол онцлог бөгөөд иймэрхүү ахуй амьдралаас тиймэрхүү сэтгэхүй, зан үйл, амьдралын арга барилыг бий болгожээ. Үүнийг “Баруун шилийн өвс”, “Баруун зүгтээ харлаа”, “Баруун шилээр байртай” гэх мэт олон дуу

гэрчилж байна. “Баруун шилийн өвс” гэх Алшаа ардын дуунд бадгуудын эхний мөрийг “баруун шилийн өвс”-өөр эхлүүлж, хоёрдугаар бадгийг “хойд шилийн өвс”, гуравдугаар бадгийг “зүүн шилийн өвс”, дөрөвдүгээр бадгийг “урд шилийн өвс”-өөр тус тус эхлүүлсэн бөгөөд “бадмарч найгана”, “хонгорлож найгана”, “зүлгэрч найгана”, “униарлаж найгана” гэж дүрсэлсэн нь нийт монгол үндэстний зүг чигийг бэлгэдэх сэтгэлгээг төлөөлж байна. Эртний энэтхэгийн үлгэр домогт өгүүлдэгчлэн Гаслангуй модонд сайхан бүсгүйн хөл хүрэхэд салаа мөчрөөс нь цэцэг жимс гардаг шиг профессор Эрдэнэбилигийн сурган хүмүүжүүлж ирсэн зам мөр, эрдэм сургаал, сэтгэлийн таалалд шадарлагч хэн хүнд эрдэм оюуны охь шим өөрөө боловсорч, мөнхийн орь залуу насны хутгийг хүртсэн мэт ухаан билгийн үр шимээ хайрласаар ирсэн оюун төгс учир ойрад ардын дууны судлалаар эрдэм төгссөн хүн хэмээн өргөмжилж байна.

3. Ойрад ардын дууны шүлэгт хийсэн шинжилгээ

Профессор Эрдэнэбилэг бол монгол ардын дууны судлалд томоохон байр эзлэх эрдэмтэн болохыг энэхүү бүтээл нь баталж байна. “Ойрад ардын дууны судлал” бүтээл бол монгол аман зохиол, утга зохиол судлалд оруулсан томоохон хувь нэмрийн нэг бөгөөд бид энэ хэсэгт тус номд орсон нийт дууны шүлэгт орчин үеийн судалгааны арга болж буй машин сургалт, программын аргыг ашиглан дүн шинжилгээ хийж үзлээ.

Энэхүү бүтээл нийт 14 бүлгээс бүрдэхдээ Ойрад ардын дууг бүх талаас нь эмхэтгэн цуглуулж судлан шинжилснээрээ монгол аман зохиол судлалын маш том хэрэглэгдэхүүн болох юм. Эндээс дууны үүсэл, хөгжил, дуулах арга ухаан, ёс заншлаас гадна Ойрадын угсаатан ястан бүрийн дууны уламжлал, онцлог, хөдөлмөрийн хийгээд зан үйлийн дуу, түүхэн хийгээд аж байдлын дуу мөн түүнчлэн дуутай бүжгийн уламжлал, Ойрад дууны аялгуу болон шүлгийн онцлог, Ойрад ардын дуунд тусгалаа олсон малын зүс, мал аж ахуйн соёлын онцлогийг маш дэлгэрэнгүй судлан оруулсан нь дан ганц аман зохиол судлал гэлтгүй түүх угсаатан судлал, урлаг, соёл судлал, хэлний шинжлэл зэрэг маш олон талын судалгааны чиглэлийг хамарсан маш үнэ цэнтэй бүтээл болсон. Бүтээлд орсон дууны шүлгийг туршилтад ашиглахаар түүвэрлэн авахад 400 гаруй дууны шүлэг байсан бөгөөд сэдэв тус бүрээр нь тайлбарлан оруулсан нь зөвхөн дууны шүлгийн түүвэр нь тусдаа ардын дууны эмхэтгэл болохоор том хэмжээний бүтээл болж байна. Ийн түүвэрлэсэн шүлгийн өгөгдөлд хийсэн туршилтын үр дүнг тус хэсэгт орууллаа.

“Ойрад ардын дууны судлал” номд БНХАУ-ын Шинжаан², Хөхнуур³, Ганьсу⁴, Алшаа⁵, Эзнээ⁶ ардын дуу, Монгол улсаас захчин⁷, дөрвөд⁸, мянгад⁹, өөлд¹⁰, баяд¹¹, урианхай¹², торгууд¹³, буриад¹⁴ ардын дууны ном эмхэтгэл, нэг сэдэвт бүтээл, өгүүлэл, тэмдэглэл нэг бүрийг бүртгэн гаргаж эх сурвалж болгосон төдийгүй хээрийн судалгаанд өөрийн биеэр

² Д. Шагай, З. Доржаараа эрхлэн найруулав: “Дундад улсын Шинжааны монгол ардын дууны эмхэтгэл”, Шинжааны ардын хэвлэлийн хороо, 2007 он.

³ Цэрэнбал, Гүнрэгмаа цуглуулан эмхэтгэв: “Дээд монголын ардын дуу”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2000 он.

⁴ Чү.Чойжив, С.Цагаанзуу найруулан зохиов: “Сүбэйгийн монгол ардын дуу зуун эх”, Ляонингийн үндэстний хэвлэлийн хороо, 2016 он.

⁵ Вэй, Баатар, Чоймбол, Хад, Дүүдэй нар цуглуулан эмхэтгэн найруулав: “Монгол ардын дууны цуврал - Алшаа аймгийн түүвэр” (дээд, доорд), Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1988 он.

⁶ Х.Өлзий үгийг тэмдэглэж, Хад аяыг нотлов: “Баян Харуугийн унага” (дээд, доорд), Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2005 он.

⁷ Э.Пүрэвжав, Б.Катуу эмхэтгэв: “Захчин ардын дуу”, Улаанбаатар, 2005 он.

⁸ Санжийн Миеэжав эмхэтгэв: “Дөрвөд ардын дуу”, Улаанбаатар, 2004 он.

⁹ Д.Лхам эмхэтгэв: “Мянгад ардын зан үйл, аман зохиол”, Улаанбаатар, 1991 он.

¹⁰ Н.Агваандорж: “Өөлд ардын уртын дуунууд”, Жаргалант, 1992 он.


¹¹ Б.Катуу: “Баяд ардын аман зохиол”, Улаанбаатар, 2011 он.

¹² С.Сонинтор: “Баян цагаан нутаг”, Улаанбаатар, 1997 он.

¹³ Д.Өрнөхдэлгэр нар: “Торгууд аман билгийн жишээ”, Улаанбаатар, 2020 он.

¹⁴ Ж.Цолоо, Г.Гантогтох эмхэтгэв: “Арван гурван ноёдын дуу”, Улаанбаатар, 2007 он.

оролцож цуглуулсан эх хэрэглэхүүн, жишээ баримтыг түшиглэн бичжээ. “Эрдэм шинжилгээний ажилд өмнөх үеийн эрдэмтнийг хүндэтгэн үзэхийн хамт тэдний олсон үр дүнд шүүмжлэлтэй хандах хэрэгтэй” (Баттөмөр, 2005: 186) зарчмаар хандсан нь уг номын бас нэг үнэ цэн орших билээ.



Зургаас харахад “МИНЬ”, “САЙХАН”, “БҮҮВЭЙ”, “БАЙНА”, “ЧИНЬ”, “ЦАГААН”, “МОРЬ” зэрэг үгс хамгийн түгээмэл хэлэгдсэн байна. “Ойрад ардын дууны судлал” номд буй шүлгүүдээс ажиглахад Халх уртын дууны суман хэмжээний дууны шүлэгтэй дөхүү байна. Төв халхын суман хэмжээний уртын дуунд “МИНЬ”, “ШҮҮ”, “ЗЭЭ”, “МОРЬ”, “САЙХАН” гэх үгс хамгийн түгээмэл хэлэгдэж байгааг *зураг 2-т* харуулав.



Зураг 2. Төв халх ардын суман уртын дууны шүлэг дэх түгээмэл үгс

Төв халхын суман уртын дуу нь айзам уртын дууны болон бэсрэг уртын дууны аль алины шинжийг агуулдагараа онцлогтой. Суман болон бэсрэг уртын дууны шүлэг нь ахуй амьдрал, амраг сэтгэлийн сэдэв голчилдог бөгөөд хамсрах утга нь байгаль дэлхий, хүлэг морио магтан дуулсан, зааж сургасан, захисан шинжтэй байдаг. “ЗЭЭ” хэмээх аялга нэлээд өндөр хувьтай байгаа нь айзам уртын дууны шинж байгааг харуулж байна. “ШҮҮ” хэмээх анхааруулах, батлах утгатай хүч нэмэгдүүлэх сул үг олон байгаа нь анхааруулсан, захисан утга бүхий бэсрэг уртын дууны шинж суман дуунд байгааг нотолж байна. Мөн “МОРЬ” хэмээх үг өндөр хувьтай байгаа нь энэ төрлийн дуунд адуун соёлын талаар түлхүү өгүүлдгийг харуулж байгаа бөгөөд “САЙХАН” хэмээх үг түгээмэл байгаа нь монголчуудын оюун сэтгэлгээний илэрхийллийг харуулж байна (Баярсайхан.Н, 2024: 112-113).

Тэгвэл Ойрад ардын дууны шүлэгт мөн “МИНЬ”, “ЧИНЬ”, “МОРЬ”, “САЙХАН” гэх үгс түгээмэл байгаа нь энэ хоёр бүс нутгийн дууны шүлэг дэх дөхүү байдлыг харуулж байна.


Хүснэгт -1. Ойрад ардын дууны шүлгийн статистик тоо

№	Үг	Хувь	Үгийн давтамж
1	минь	1.07 %	204
2	бүүвэй	0.98 %	186
3	сайхан	0.90 %	171
4	байна	0.81 %	155
5	чинь	0.79 %	151
6	нь	0.76 %	144
7	цагаан	0.60 %	114
8	морь	0.53 %	101
9	би	0.50 %	96
10	хоёр	0.43 %	81
11	хар	0.42 %	79
12	бий	0.39 %	75

13	төрсөн	0.38 %	72
14	ээж	0.37 %	71
15	буй	0.37 %	70
15	нар	0.37 %	70
16	хөөрхий	0.35 %	66

Монгол ардын дууны үг, аялгуу хоёр нь маш нарийн шүтэлцээтэй бөгөөд ялангуяа уртын дуу нь ямагт сонгодог бичгийн хэлний найруулгатай байдаг. Сонгодог найруулга нь хүндэтгэлийн утга илэрхийлж байдаг. Айзам хэмжээний уртын дууны шүлэг ихэвчлэн задгай шүлгийн ёсыг баримталдаг, уянгын яруу найргийн хэлбэрээр уламжлагдаж ирсэн байдаг бол суман болон бэсрэг уртын дууны шүлэг голдуу чанарын шүлгийн өргөлтөт болон үе өртгөлтөт зүйлээр бичигдсэн байдаг. Энэ байдлыг Ойрад уртын дууны шүлгээс харж болохоор байна.

WORD FREQUENCY CHART



Зураг 2. Ойрад ардын дууны шүлэг дэх үгсийн эзлэх хувь

Графикаас харахад “МИНЬ” гэдэг үгийн эзлэх хувь хамгийн их байгаа бол “ЦАГААН” гэдэг үг удаалж байна. “МИНЬ” хэмээх төлөөний үг нь аливаа зүйлийг хамаатуулан өөриймсүүлэх монгол сэтгэлгээг бүрнээ илэрхийлдэг. Харин морины зүс болох “ЦАГААН” гэх үгийн тухайд морины зүснээс гадна цагаан сэтгэл, цагаан сүү мэтийн аливаа зүйлийг эерүүлэн цагаан өнгөөр бэлгэддэг монгол сэтгэлгээг мөн адил тод харуулж байна.

4. Дүгнэлт

Профессор Эрдэнэбилиг нь ардын дуучдын тухай судлалыг чухалчилж, тэдний түүх намтар жич дуулсан дууных нь үүсэл гарал, уламжлал залгамжлалын жам ёсыг анхааран судалсан нь ардын дууны уламжлал шинэчлэл, хөгжлийг нарийвчлан судлахад маш чухал нөлөө үзүүлсэн юм. Энэхүү зуунаас зуунд үе улиран уламжлагдан ирсэн ойрад ардын дууны урлагийн их ундраа болох уртын дууны дуулах арга барилыг өвлөн авч, монгол түмний язгуур соёл урлагийн баян тансаг соёлын өвийг цаашид сурвалжлан судалж, дэлхийн соёл урлагийн сан хөмрөгт оруулах ирээдүйн их үйлсэд тус нэмэр болсон жинтэй бүтээлийг насан турхруу туурвин бичсэн онцгой гавьяатай эрдэмтэн юм.

Монголчууд ардын дуугаа төрт ёсны болон ахуй амьдралынхаа хамгийн хүндэтгэлтэй арга хэмжээнд, аливаа зан үйлдээ зориулан дуулж ирсэн түүхтэй. Уртын дуу дуулахад ад чөтгөр зайлж, аюул ослоос хамгаалдаг гэх өвгөдийн ярианаас үзвэл бөөгийн дуудлага, тамлагатай чанарын хувьд ижил хэмээн үзэж болно. Иймэрхүү төрлийн зан үйл, итгэл бишрэл монголын бүхий л угсаатан ястанд байдаг гэдгийг энэхүү судалгааны бүтээл дахин баталж, баримт нотолгоо, эх сурвалжийг дурдан өгүүлсэн байна.

Түүхийн тавцанд Монгол гэх нэрийн дор уламжлалт зан үйл, урлаг соёл, үзэл санаагаараа нэгэн бие болон түмэн үеийг элээсэн олон арван монгол угсаатан, ястны мартаж болшгүй өв соёл болох ардын дууны сургаал тээсэн шүлэг яруу найраг, сэтгэл амарлиулах хөг аялгуу өнө мөнхөд эгшиглэн үеийн үед өвлөгдөн байх их замыг заасан энэхүү бүтээл он цаг өнгөрөх тусам улам улам үнэ цэнтэй болно.

Ном зүй

- Батгөмөр, Д.** (2005). *Логик эпистемологи, шинжлэх ухааны философийн асуудлууд*. Улаанбаатар. [Battumur,D. *Logic epistemology, shinlekh uhaany philosphiin asuudhuud* [The Issues of Logical Epistemology and Philosophy of Science]. Ulaanbaatar: 2005]
- Баярсайхан,Н.** (2024). *Төв халх уртын дууны шүлгийг туршилтын аргаар шинжлэх нь*. докторын диссертаци. Улаанбаатар. [Bayarsaikhan.N, *Tuv khalkhyn urtyн duug turshiltyn argaar shinjlekh ni* [The Experimental Analysis of the Lyrics of Central Khalkha Long Songs]. Ulaanbaatar: 2024]
- Дулам,С., Нандинбилиг,Г.** (2007). *Монгол аман зохиолын онол I: Аман яруу найраг*. Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Dulam,S., Nandinbilig,G. *Mongol aman zohyol I: Aman yaruu nairag*. [The Theory of Mongolian Oral Literature I: Oral Poetry]. Ulaanbaatar: Soyombo printing LLC. 2007]
- Шагай,Д., Доржаараа,З.** (2007). *Дундад улсын Шинжааны монгол ардын дууны эмхэтгэл*, Өрөмч: Шинжааны ардын хэвлэлийн хороо. [Shagai,D., Dorjaaraa,Z. *Dundad ulsyn Shinjaany mongol ardyn duuny emkhetgel* [A Collection of Mongolian Folk Songs from Xinjiang, China] Urumch: Xinjiang people's Publishing. 2007]
- Эрдэнэбилиг,Д., Гүй Лан.** (2024). *Ойрад ардын дууны судлал*. Монгол бичгээс хөрвүүлж, эрхлэн найруулсан Д.Өрнөхдэлгэр, Редактор Н.Баярсайхан, Улаанбаатар: Соёмбо принтинг ХХК. [Erdenebileg,D., *Gui Lan. Oirat ardyn duuny sudlal* [The Study of Oirat Folk Songs] Ulaanbaatar: Soyombo printing LLC. 2024]